

6-р зүйлийн хэрэгжилтэд Японы хандлага: Хамтарсан кредит олгох механизмын үүрэг болон сүүлийн үеийн ахиц

Кэйтaro ЦҮЖИ

Захирал

**Хамтарсан кредит олгох механизм болон олон улсын
нүүрстөрөгчийн зах зээлийн хэлтэс**

Байгаль Орчны Яам, Япон улс

2026 он 2-р сарын 27



Ministry of the Environment

1. Хамтарсан кредит олгох механизмын (ХКОМ) тухай
2. ХКОМ-ын сүүлийн үеийн мэдээ
3. Монгол, Японы хоорондын ХКОМ-ын хамтын ажиллагаа




1. Хамтарсан кредит олгох механизмын (ХКОМ) тухай

Хамтарсан кредит олгох механизмын (ХКОМ) тухай

- ХКОМ нь Японы компаниуд болон Засгийн газраас түнш орнуудад (өнөөдрийн байдлаар 31 улс) хэрэгжүүлж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанд хамтран оролцох боломжийг бүрдүүлдэг нүүрстөрөгчийн зах зээлийн хэрэгсэл юм.
- Нийт бууруулалтын үр дүнгээс хоёр талын Засгийн газрууд оруулсан хувь нэмрийнхээ хэмжээнд тулгуурлан, ХКОМ кредитийг тооцоолж, зөвшөөрөл олгож, консерватив байдлаар хуваарилдаг. Энэ үйл явц нь Парисын хэлэлцээрийн 6-р зүйлийн шаардлагуудтай нийцсэн байдаг.
- ХКОМ нь Японы нүүрстөрөгч багасгах төслүүдэд хийх хөрөнгө оруулалтыг дэмжиж, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC)-ийг биелүүлэх болон тогтвортой хөгжлийг хангах зэрэг олон талын үр өгөөжийг бий болгодог.

Бууралтын үр дүн ба түүний шилжүүлэлт



Японы хөрөнгө оруулалттай нүүрстөрөгч багасгах төслүүд



Сэргээгдэх



Энерги хэмнэлт



Хог



Ойн аж ахуй




Хөдөө аж ахуй



Нүүрстөрөгч ялган авах ба хадгалах

ХКОМ-ын кредитийн урамшуулал нь төслийн зардлыг бууруулахад дэмжлэг үзүүлдэг.

- ХКОМ нь Японы нүүрстөрөгч бууруулах төслүүдэд оруулах хөрөнгө оруулалтыг дэмжиж, дараах олон талын үр өгөөжийг бий болгодог:
 - Түнш оронд хэрэгжих нүүрстөрөгч багасгах материал/эрчим хүчний үнийг бууруулах.
 - Түнш орны дотоодын нийлүүлэгчдийн нийлүүлэлтээс олох ашгийг өсгөхөд хувь нэмэр оруулдаг.



Дэвшилтэт нүүрстөрөгч бууруулах тоног төхөөрөмж ба байгууламж

Нийт 296 ХКОМ-ын Төслүүд



*Дугаарууд нь гарын үсэг зурсан дарааллыг илэрхийлнэ.

* МОЕ болон МЕТ1 мөн хувийн хэвшлийн дэмжлэгтэй хэрэгжиж буй ХКОМ төслүүдийн нийт тоо.

Дэлхий даяар 3 тэрбум ам.доллараас давсан хөрөнгө оруулалттай, 290-ээс илүү ХКОМ төслүүд хэрэгжээд байна

Сэргээгдэх Эрчим Хүч



Нарны эрчим хүч,
FARMLAND Co., Ltd., Чили



Хөвөгч Нарны PV
систем, TSB Co., Ltd., Тайланд



УЦС, Toyo Energy Farm Co.,
Ltd., Индонез



Биогас Цахилгаан Үйлдвэрлэл, ITOCHU
Corporation, Филиппин



ГЦС дахь хоёртын цахилгаан
үйлдвэрлэлийн төсөл, MHI, Ltd.,
Филиппин

Эрчим хүчний хэмнэлт [Хэрэглэгчийн салбар]



Түргэн үйлчилгээний
дэлгүүрүүдийн эрчим хүчний
хэмнэлт, Panasonic, Индонез



Өндөр үр ашигтай
хөргөгч, Maekawa MFG,
Индонез

Эрчим хүчний хэмнэлт [Аж үйлдвэрийн салбар]



Нефть боловсруулах үйлдвэрийн
процессийн оновчлол, Yokogawa
Electric Corp.
Индонез



Суурин станцын эрчим хүчний
хэмнэлт,
KDDI Corp.
Индонез

Эрчим хүчний үр ашигтай ашиглалт




Хийн когенерацийн систем
болон абсорбцийн хөргөгч,
Kansai Electric Power, Тайланд

Эрчим хүчний хэмнэлт [Хотын салбар]



Ухаалаг утасгүй сүлжээний
удирдлагатай LED гудамжны
гэрэлтүүлгийн систем,
MinebeaMitsumi, Камбож



Аморф голтой түгээлтийн
трансформатор,
Yuko-Keiso, Виетнам

Хог хаягдал



Метан нөхөн сэргээх ба
цахилгаан үйлдвэрлэл,
NTT DATA, Мексик



Хог-эрчим хүчний
үйлдвэр, JFE engineering,
Виетнам


Тээвэр



CNG-дизель хосолмол
автобус, Hokusan Co.,
Ltd., Индонез


ХКОМ-ын хүрээнд бууруулалтын үр дүнг үнэлэх ба кредит олгох үйл явц

- ХКОМ-ын кредит хэлбэрээр олгогдох бууруулалтын үр дүн нь төслийн ялгаруулалт болон түнш улсын хамгийн сүүлийн үеийн NDC-ийг харгалзан тогтоосон суурь ялгаруулалтын хоорондын зөрүүгээр тооцогддог.
- Бизнес-ийг хэвээр үргэлжлүүлэх нөхцөл (BaU) болон төслийн бодит ялгаруулалтын зөрүү болгон тооцогдох ХКОМ төслүүдийн нийт бууруулалтын үр дүн нь дараах гурван хэсгээс бүрдэнэ. Үүнд: 1.ХКОМ кредит болгон олгохгүй үлдэх бууруулалтын үр дүн; 2.Түнш улсуудын эзэмшихээр олгогдсон ХКОМ кредит; 3.Японы эзэмшихээр олгогдсон ХКОМ кредит. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэг нь бүгд тухайн улсуудын NDC-ийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулдаг.
- Нийт бууруулалтын үр дүнг ХКОМ-ын төсөлд оролцогч талуудын (хоёр улсын Засгийн газар болон оролцогч байгууллагуудын) хувь нэмрийг харгалзан хоёр тал хэлэлцэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр хуваарилна. Хувь нэмэр гэдэгт хувийн хэвшил болон төрийн санхүүгийн хувь нэмэр, мөн техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг зэрэг биет бус оролцоо багтана.



ХКОМ төслийн процесс ба хувийн хэвшлийн үүрэг

<Төсөл бүрээр>




2. ХКОМ-ын сүүлийн үеийн мэдээ

2025 онд ХКОМ-ын хүрээнд хийгдсэн ажлууд

11

- 2025 оны 4-р сард ХКОМ хэрэгжилтийг дэмжих агентлаг (JСМА) байгуулагдсан.

- ХКОМ-ын шинэ түнш орнууд:
Танзани (5-р сард) and Энэтхэг (8-р сард)



- 6-р зүйлийн анхны тайлан ба техникийн шинжээчийн үнэлгээ (A6TER)
 - Япон улс 2025 оны 10-р сарын 14-нд шинэчлэгдсэн анхны тайлангаа өргөн мэдүүлсэн.
 - 6 түнш улс ХКОМ-ын хүрээнд 6-р зүйлийн Хэрэгжилтийн Түншлэлийн Төв (A6IP)-ийн техникийн дэмжлэгтэйгээр өөрсдийн анхны тайлангаа өргөн мэдүүлсэн.
 - Япон болон 5 түнш улс A6TER багийн техникийн шинжээчийн хяналт-үнэлгээнд хамрагдсан.
- ХКОМ-ын хүрээнд анхны болон хоёр дахь ITMO олголт
 - 1 дэх ITMO олголт — Япон-Тайланд хооронд 2025 оны 11-р сарын 11-нд хийгдсэн.
 - 2 дахь ITMO олголт — Япон-Мальдивын хооронд 2025 оны 12-р сарын 16-нд хийгдсэн.
- 2025 оны 12-р сарын 8-нд ХКОМ төслүүдийн өргөдлийн шалгуурыг нийтэлсэн

Тайланд болон Мальдив улсуудын ХКОМ-ын кредитэд хамаарах ITMO-үүд

12

- ХХ-ны шийдвэр: JC7, 2025 оны 10-р сарын 30 
- ITMO-ийн баталгаажилт дууссан огноо: 2025 оны 11-р сарын 11
- Төслийн нэр: “Тайландад аж үйлдвэрийн усан сан дээр 5 МВт хүчин чадал бүхий хөвөгч нарны цахилгаан станц нэвтрүүлэх” (TH014)
- Эрх олгосон ITMO-ийн хэмжээ: 1,009 tCO₂eq
- Бууралтын тооцоологдсон жил: 2021




- ХХ-ны шийдвэр: JC5, 2025 оны 12-р сарын 16 
- ITMO-ийн баталгаажилт дууссан огноо: 12-р сарын 17
- Төслийн нэр : Адду хотод ухаалаг жижиг эрчим хүчний сүлжээ нэвтрүүлэх (MV002)
- Эрх олгосон ITMO-ийн хэмжээ: 433 tCO₂eq
- Бууралтын тооцоологдсон жил: 2021 – 2022



2025 оны 2-р сард шинэчилсэн Японы NDC

13

- Япон улс **2050 он гэхэд цэвэр тэг ялгаруулалтад** хүрэх зорилготой. 2025 оны 2-р сард шинэчлэн баталсан NDC-д, Япон нь дэлхийн 1.5°C-ийн зорилттой нийцүүлэн 2013 оны **түвшнээсээ 2035 онд хүлэмжийн хийн ялгаруулалтаа 60%-иар, 2040 онд 73%-иар бууруулах** зорилтуудыг тавьсан.
- Шинэчилсэн NDC-д зааснаар, **Япон улс ХКОМ-ын хүрээнд 2030 он гэхэд дэлхийн хэмжээнд 100 сая тн-CO₂, 2040 он гэхэд 200 сая тн-CO₂-ийн бууралтад хувь нэмэр оруулах зорилт тавьсан.** *Эдгээр нь **кредитийн тоо хэмжээ бүс** хуримтлагдсан бууралт юм.
- Эдгээр зорилтууд нь **дунд болон урт хугацааны тодорхой байдлыг нэмэгдүүлж, Ногоон Шилжилт (GX)-ийн хөрөнгө оруулалтыг хурдасгахад чиглэнэ.**



- Япон улс 2026 оны санхүүгийн жилд дотоодын зохицуулалттай нүүрстөрөгчийн зах зээл (GX-ETS)-ийг нэвтрүүлнэ.
 - Жилд ойролцоогоор **600 сая тн- CO_2 -ийг** хамрах заавал хэрэгжүүлэх ялгаруулалтын худалдааны тогтолцоо (ETS)
- Япон улсад ХКОМ-оор эзэмшсэн кредитүүдийг **GX-ETS-ийн хүрээнд компаниудын заавал биелүүлэх ялгаруулалтын зорилтуудыг** (caps) хангахад ашиглах боломжтой. Энэ нь **ХКОМ кредитийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлнэ**.

GX-ETS (Ялгаруулалтын Худалдааны Тогтолцоо) болон Нүүрстөрөгчийн Зах Зээл



ХКОМ төслүүдийн өргөдлийн шалгуур

1. ХКОМ-д төслийг хамруулахын тулд тухайн төсөл **ХКОМ-ыг ашигласнаар нэмүү өртөг бий болгож буйг нотлох** шаардлагатай. Дараах үзүүлэлтүүдийг хангах:
 1. **Төслийн амьдрах чадварыг хангахад кредитийн урамшуулал зайлшгүй шаардлагатай байх** (жишээлбэл, кредитийн орлогоос өөр орлого төлөвлөгдөөгүй байх, эсвэл орлого төлөвлөсөн ч кредитийн орлого байхгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын нөхөх хугацаа уртсаж, дотоод өгөөжийн хувь (IRR) буурах тул төслийг хэрэгжүүлэхэд хүндрэл учрах гэх мэт). Гэхдээ IRR, нөхөх хугацаа зэрэгт тоон стандарт тогтоохгүй.
 2. Түнш улсын NDC-д хувь нэмэр оруулах үүднээс, тухайн төслийн **технологийн төвшний хүндрэл, цар хүрээ, эсвэл хэрэгжүүлэх хурд** зэрэг тодорхой үзүүлэлтүүдийн хувьд **онцгой давуу талтай** болохыг нотлох шаардлагатай.
 3. Түнш улсын дотооддоо өргөжин тэлэх боломж — үүнд дотоодын компаниудын оролцоо, мөн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа болон технологи нэвтрүүлэлтээр дамжин дотоодын үйлдвэрлэл, салбаруудад үзүүлэх ашиг тус багтана.

Төлөөлж буй компани дээрх асуудлуудыг тайлбарлан танилцуулах шаардлагатай. Үүний үндсэн дээр болон **тухайн салбарын онцлог зааварчилгаа, аргачлалуудыг** суурь болгон, холбогдох яамд болон төрийн байгууллагууд нь **олон улсын түвшний хариуцлагын шаардлага** зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж, **ХКОМ-ын хамрагдах боломжийг бүх талаас нь үнэлэн** шийдвэрлэнэ.

ХКОМ төслүүдийн өргөдлийн шалгуур (Үргэлжлэл)


2. Хүлэмжийн хийг бууруулах чиглэлийн тоног төхөөрөмжийн худалдан авалт эхлэх, эсвэл барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх өдрөөс өмнө, **Төслийн тодорхойлолт (PIN)** нь Япон Улсын Засгийн Газрын шугамаар дамжин Түнш улсын Засгийн газарт хүргэгдсэн байх. Хэрэв тоног төхөөрөмжийн худалдан авалт эсвэл барилга байгууламжийн ажил аль хэдийн эхэлсэн төслүүдийг **дараах тохиолдолд уг шаардлагаас чөлөөлнө. Нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөс** (жишээлбэл, бизнесийн орчны өөрчлөлтөөс болж үргэлжлүүлэх боломжгүй болсон гэх мэт) шалтгаалан, төслийг төлөөлж буй компани 1-р бүлэгт заасанчлан кредитээс авах урамшуулал болон нэмүү өртгийн хэрэгцээ үүссэн гэдгийг **үндэслэлтэй тайлбарласан байх** мөн ХКОМ-д хамруулах зорилготойгоор тоног төхөөрөмж, байгууламжийн холбогдох зардал дээр **төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж буй төслүүд** хамаарна.
3. 2-р бүлэгт дурдсан нөхцөл нь, хүлэмжийн хий бууруулах зориулалтаар тоног төхөөрөмж худалдан авах шаардлагагүй төслүүдэд (**жишээ нь ойн салбар, хөдөө аж ахуйн салбар, газар ашиглалтын салбар**) хамаарахгүй бөгөөд эдгээр төслүүдийг уг шаардлагаас **чөлөөлнө**. Ойн салбарын хувьд, Япон болон Түнш улсын хооронд ХКОМ-ын тус салбарын зааварчилгаа батлагдахаас өмнө үйл ажиллагаанууд эхэлсэн, эдгээр нь зааварчилгаанд тусгагдсан шаардлагуудыг хангаж байвал ХКОМ-д хамрагдах боломжтойд тооцогдоно.
4. **PIN** нь хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагаанд **Японы компаниуд болон Засгийн газрын гүйцэтгэх үүргийг тодорхой заасан байх, Японы талын санхүүгийн хувь нэмрийг тоон илэрхийллээр тодорхойлон** тусгасан байх шаардлагатай.

Төслийн санал ХКОМ-ын төслөөр батлагдахын тулд Түнш улсын Засгийн газартай харилцан зөвшилцөлд хүрэхийг шаарддаг бөгөөд дээр дурдсан шалгууруудыг хангаж байгаа нь ХКОМ-ын төслийн баталгаажуулалт заавал хийгдэнэ гэсэн баталгаа болохгүй.

3. Монгол, Японы хоорондын ХКОМ-ын хамтын ажиллагаа

Монгол Улс болон Япон Улс нь ХКОМ-ыг
2013 онд эхлүүлсэн.

- Анхны ХКОМ-ын түнш улс!
- Монгол Улсад ХКОМ-ын 7 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр нь хүлэмжийн хий бууруулахад бодит үр дүн гаргаж, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна.



■ **Дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох**

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн хүрээнд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийн дотоодын баталгаажуулалтын тогтолцоог түргэн хугацаанд бүрдүүлэх.
- Хууль албан ёсоор мөрдөгдөж эхлэх хүртэл одоо хэрэгжиж буй ХКОМ-ын төслүүдийн үйл явцыг үргэлжлүүлэх.


■ **ХКОМ-ын Дүрэм болон Зааварчилгаа**

6 дугаар зүйлийн хүрээнд нийцүүлэн, Дүрэм болон Зааварчилгааны шинэчлэлтийг Хамтарсан Хороо батлана.

Хавсралт

Төсвийн дэмжлэггүй ХКОМ-ын төслүүд: 100 төлөвлөгдөж буй төслүүд

- 2025 оны 2 дугаар сарын байдлаар бид дараах байдлаар ойролцоогоор 100 зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна.
- Төслийн ихэнх нь малтмал бус эх үүсвэрээс гарах ХХЯ-г бууруулах зорилготой.



1. **Нэгтгэл:** ХКОМ-ын есөн тусдаа зааврыг нэг баримт бичигт нэгтгэж, 6.2 дугаар зүйлийн удирдамжийн шаардлагыг тусган ерөнхий шинэчлэл хийсэн.
2. **Зээлжих хугацаа:** 10 жилийн тогтмол хугацаа эсвэл 5 жилийн сунгах боломжтой хугацаа - дээд тал нь 15 жил.
3. **Төслийн тодорхойлолт (PIN):** PIN-ийг Хамтарсан Хороогоор шийдвэрлэнэ.
4. **Тогтвортой хөгжлийн тайлагнал:** Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн төлөвлөгөөний (төслийг бүртгүүлэх үеийн урьдчилсан) болон тайлангийн (зээл олгох үеийн дараах) зааврыг шинэчлэн тусгасан. * **А6-тай холбогдох.**
5. **Зөвшөөрөл олголт:** Хоёр талын Засгийн газрууд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш үүссэн Японы ХКОМ-ын бүртгэлийн системд олгогдсон кредитүүдийг Японы Үндэсний Хувь Нэмрийг биелүүлэхэд ашиглахыг зөвшөөрч, 6.2 дугаар зүйлийн удирдамжтай нийцүүлэн холбогдох зохицуулалтыг хийдэг. * **А6-тай холбогдох**
6. **2030 оны хугацааны шаардлагыг хүчингүй болгох**
7. **ХКОМ кредит олголт:** ХКОМ-ын төслийн оролцогчид хоорондоо болон хоёр талын Засгийн газартай зөвлөлдөж, Японы төслийн оролцогчид, (Түнш орны) төслийн оролцогчид, Японы Засгийн газар болон (Түнш орны) Засгийн газар хооронд хуваарилагдах зээлийн хэмжээг өөрсдийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг харгалзан үзэж тогтооно.
8. **Суурь ялгаруулалт:** Суурь ялгаруулалтыг тухайн санал болгож буй төсөл нь түнш улсын Үндэсний Хувь Нэмрийг биелүүлэхэд хувь нэмэр оруулах байдлаар тогтооно. * **А6-тай холбогдох**
9. **ISO / 6.4 дугаар зүйл:** ISO-гийн сүүлийн хувилбар болох ISO 14065-ын шаардлагыг тусгахаар, голчлон Баталгаажуулалт ба Хяналтын зааварт шинэчлэл хийсэн. ТРЕ (Гуравдагч талын байгууллага)-д тавигдах шалгуурын хүрээнд, 6.4 дүгээр зүйлийн DOE-г албан ёсоор хүлээн зөвшөөрдөг болсон.

ХКОМ-ын вебсайт

URL: <https://www.jcm.go.jp/>


Агуулга

- Ерөнхий танилцуулах хуудас
- ХКОМ Түнш орнууд – Япон улсын хуудас

Үйл ажиллагаа

- Олон нийтэд нээлттэй мэдээллүүд,
 - Хамтарсан хорооны шийдвэрүүд
 - Дүрэм, журам
 - Аргачлал болон төслүүд
 - ХКОМ-ын кредит олголт
 - Олон нийтийн санал хүсэлт
 - ТРЕ тухай,
- Хамтарсан хорооны гишүүдэд зориулсан дотоод мэдээлэл солилцоо,
 - ХХ-ийн цахимаар гаргах шийдвэрүүдийн баримт бичгийг хуваалцах

▼Ерөнхий танилцуулах хуудсын зураг



▼ХКОМ-ын түнш орнууд – Япон улсын хуудасны зураг

